

БАТЛАВ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН**

С.БЯМБАЦОГТ

**ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

Төрийн үндсэн чиг үүргүүдийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлж хамгаалах, хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх замаар нийгэмд шударга ёс, дэг журмыг тогтооход оршдог.

Төрийн энэхүү үүргийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн." гэж, Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтад: "эрүүл, аюулгүй орчинд амьдрах,... эрхтэй." гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж тус тус зааж, бэхжүүлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т "Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн." гэж зааж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байхаар заасан.

Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 149 дэх хэсэгт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар заасан.

Монгол Улсад 1990-ээд оноос хойш 20 гаруй жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харахад эрүүгийн хууль тогтоомжид заасан 200 гаруй гэмт хэргээс 6-7 төрлийн гэмт хэрэг Монгол Улсад гарч буй нийт гэмт хэргийн 80 гаруй хувийг тогтмол эзэлж байна. Тухайлбал, хулгайлах гэмт хэрэг нийт бүртгэгдэж буй гэмт хэргийн 30 гаруй хувийг, бусдын бие махбодид гэмтэл учруулах төрлийн гэмт хэрэг 30 орчим хувийг, мөн залилан мэхлэх гэмт хэрэг 10 орчим хувийг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөн ойролцоо хувийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд шинэ төрлийн гэх нэршил аваад байгаа мансууруулах эм,

сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдалах болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тоог нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоотой харьцуулахад эзлэх хувь бага боловч нийгэмд учруулах хор уршиг, аюулын хувьд өндөр бөгөөд сүүлийн жилүүдэд тоо нь хурдацтай өсөж байна.

Монгол улсад гэмт хэрэг гаралтын тоо сүүлийн 10 жилийн хугацаанд тогтмол өсч ирсэн ба гэмт хэргийн улмаас 2014 онд 148,3 тэрбум төгрөгийн хохирол учирч байсан бол 2017 онд 198,1 тэрбум төгрөг болж өссөн, 2017 онд улсын хэмжээнд 32,2 мянга орчим гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 5,0 мянга буюу 18,7 хувиар өссөн, гэмт хэргийн улмаас 37,2 мянган хүн хохирсноос 4,7 хувийг нь хүүхэд, 48,8 хувийг нь эмэгтэйчүүд эзэлж, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо өмнөх оноос 500 орчмоор нэмэгдсэн нь жил ирэх тусам гэмт хэргийн учруулж байгаа хохирол, хор уршиг өсөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Улс орны хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурахгүй байгаа төдийгүй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан хууль тогтоомжуудын уялдаа, хэрэгжилтийг хангахын зэрэгцээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн судалгааны тайлангуудад гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах эрх зүйн орчинг шинэчлэн бүрдүүлэх, гэмт явдалтай нэгдсэн бодлого, төлөвлөгөөг бий болгох, төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор тэмцэх, урьдчилан сэргийлэх, криминологийн шинэ арга, туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай талаар санал, зөвлөмжүүд тусгагдсан байгаа нь цаашид урт удаан хугацаанд үр нөлөөтэй үйлчлэх хэм хэмжээ үгүйлэгдэж байгааг илтгэж байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль нь зөвхөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай харилцааг хамаарч байгаа бөгөөд зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого, тогтолцооны талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй бөгөөд энэ асуудал нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим нэг хууль тогтоомжид зохицуулагдсан хэдий ч одоог хүртэл тухайлсан зохицуулалтгүй явж ирсэн байна. Иймд хуулийн төслийн зорилгыг “гэмт хэрэг”, “зөрчил”-өөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохицуулахаар өргөжүүлж, хуулийн төслийн бүтэц, зохицуулалтыг уг зорилгод нийцүүлэн боловсруулна. Ийнхүү боловсруулахдаа урьдчилан сэргийлэх ажлын талаархи хэм хэмжээг “гэмт хэрэг”, “зөрчил”-ийн аль альд хамаарах нийтлэг зохицуулалтыг тусгахаас гадна гэмт хэрэг болон зөрчлөөс урьдчилан сэргийлэх онцлог зохицуулалтыг ялгамжтай байдлаар тусгана.

Хуулийн төсөл нь зохицуулж байгаа харилцааны агуулга, онцлогт үндэслэн 8 бүлэгтэй байна.

Хуулийн төслийн **Нэгдүгээр бүлэгт** хуулийн төслийн зорилт, хууль тогтоомж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын тодорхойлолт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилго, үндсэн зарчмыг тусгана.

Хуулийн төслийн **Хоёрдугаар бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгана. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн гурван чиглэлийг тодорхойлсон боловч тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хуульд ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Хуулийн төслөөр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн таван чиглэл байхаар тусгах бөгөөд уламжлалт чиглэлүүдээс гадна гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэл болон гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх чиглэлийг нэмж тусгаж, чиглэл бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой заана.

Хуулийн төслийн **Гуравдугаар бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хамрах хүрээ болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг улсын болон тодорхой засаг захиргааны нэгжийн хэмжээнд уялдуулан зохицуулах талаархи зохицуулалтыг тусгана. Энэхүү бүлэгт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулах арга хэлбэр, уг чиг үүргийг хэрэгжүүлэх Зохицуулах зөвлөл, салбар зөвлөл, дэд зөвлөлийн эрх хэмжээ, эрх зүйн байдлыг тодорхойлж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулах тухай зохицуулалтыг тусгана.

Түүнчлэн энэхүү бүлэгт гэмт хэрэг, зөрчлийн талаархи нөхцөл байдлыг тогтоох зорилгоор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх, хууль сахиулах байгууллагуудын албан ёсны тоо, статистикт бүртгэгддэггүй гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшинг тогтооход чиглэсэн зохицуулалтыг тусгана. Мөн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн талаархи цахим мэдээллийн сан бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл цуглуулах, боловсруулахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Хуулийн төслийн **Дөрөвдүгээр бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаархи Засгийн газар, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нутгийн захиргааны байгууллагууд болон бусад төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд, хэвлэл, мэдээллийн байгууллагын оролцооны талаархи зохицуулалтыг тусгана.

Хуулийн төслийн **Тавдугаар бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах хэлбэрийг тусгана. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах нийт зургаан хэлбэрийг тусгах бөгөөд эдгээр нь урамшуулах, гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээллийг төлбөртэй авах, олон нийтийн шинэ санаачлагыг дэмжих, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог хангах баталгааг бүрдүүлэх хэлбэртэй байна.

Хуулийн төслийн **Зургадугаар бүлэгт** гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг тусгана. Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахдаа одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг судалж, зөвхөн “хэлбэрийн” төдий хяналт тавьж байгааг өөрчилж, хорих байгууллагаас суллагдсан этгээдэд нийгмийн амьдралд эргэн ороход нь тусламж, дэмжлэг үзүүлэхэд илүү анхаарах, бүртгэх байдлаар хяналт хэрэгжүүлэх бус хэвийн ажиллаж, амьдрахад нь садаа болдог, залхаан цээрлүүлж байгаа байдлыг зогсооно.

Хуулийн төслийн **Долдугаар бүлэгт** гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн талаархи зохицуулалтыг тусгана. Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын агуулгыг ерөнхийд нь хэвээр хадгалах боловч санхүүжилтийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгож, хөрөнгийг зарцуулах зориулалтыг өргөжүүлж, эдгээр зохицуулалттай уялдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сангийн талаархи зохицуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмнэ.

Хуулийн төслийн **Наймдугаар бүлэгт** бусад зүйл буюу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил эрхлэх болон хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалтыг тусгах бөгөөд үүнтэй уялдуулан Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Монгол Улсад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нэгдсэн бодлого, төлөвлөлт, уялдаатай, шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаанд суурилсан байдлаар явагдах боломж бүрдэнэ.

Гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурч, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө сайжирч, улмаар төр, хүн, хуулийн этгээдийн Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөг аливаа хууль бус халдлагаас хамгаалах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх баталгаа бүрдэнэ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын уялдуулан зохицуулах ажил шинэ түвшинд гарч, уг ажилд оролцох этгээдүүдийн эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, урьдчилан сэргийлэх ажлыг үнэлэх тогтолцоо бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд төсөлтэй уялдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай,

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

--oOo--